



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/123

Номгон

Шар ус, үер усны аюул, ослоос урьдчилан
сэргийлэх чиглэлээр авах зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Гол, нуурын мөс цөмрөх, шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”, Улсын онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авах хэрэгжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шар усны үер, мөс цөмрөх үерээс урьдчилан сэргийлэх зорилгоор цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан гаргаж, иргэд малчид, аж ахуйн нэгж байгууллагад шуурхай хүргэх, багц мессежээр дамжуулах, цасан бүрхүүл болон гол, нууруудын мөсний зузаанд хэмжилт хийж нэгдсэн судалгаа гаргахыг Ус, цаг уурын орчин шинжилгээний төвийн дарга (Ц.Оюунчимэг)-д даалгасугай.



2. Үерийн хамгаалалтын далан, зам гүүрийн ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламжид үзлэг, шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд даланг сэргээх суваг, шуудууг татах болон далан суваг, шуудууны цэвэрлэгээг холбогдох байгууллагаар хийлгэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-д, Баянхонгор сумын Засаг дарга (Г.Энхбаяр)-нарт

4. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тээврийн жолооч, малчид, иргэдэд гол, нуурын мөсөн дээгүүр зорихгүй байх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээг тогтмол хүргэж, гол, мөрөн, нуурын арал, тохой, эрэг дагууд болон уулын ам, бэл, гуу, жалга, сувгийн ойролцоо айл өрх, аж ахуйн нэгжийг бууж суурьшсан эрсдэл бүхий газарт нутагласан айл өрхийн судалгааг гаргаж, мэдэгдэл хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, эрсдэл бүхий газруудад урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг самбар байршуулж,

824010254

бүхий газруудад урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг самбар байршуулж, хөдөлгөөнт эргүүл (морин болон авто хэрэгсэл) ажиллуулахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Батсуурь), үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ж.Алтангэрэл) нарт тус тус даалгасугай.

ДАРГА   МӨНХСАЙХАН